



ДУНДГОВЬ АЙМАГ
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/06

Сангийндалай

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-ийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2023 онд хийгдэх "Эрдэнэдалай сумын Соёлын төвийн үзэгчдийн танхимын тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Ц.Чинбат (Гялс төгрөг хадгаламж, зээлийн хоршооны захирал)

Нарийн бичгийн дарга: Ч.Үүрцайх (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Гишүүдэд: Б.Өнөрбилэг (Олон нийтийн хэвлэл мэдээлэл хариуцсан ажилтан)

Д.Ууганбаяр (5-р багийн Засаг дарга)

А.Отгонмаа (Хүүхдийн цэцэрлэгийн нягтлан бодогч)

2. Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж, энэ тухай эрх бүхий байгууллага, албан тушаалтанд бичгээр мэдэгдэж, сонгон шалгаруулалтыг хуулийн хүрээнд зохион байгуулан, баримт бичгийн бүрдлийг хангаж архивд хүлээлгэн өгөхийг дарга гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ЛХАГВАМАНДАЛ



4823020011